

БЭЛТГЭЛ БҮЛЭГ БАГШИЙН АШИГЛАХ ДААЛГАВАР

Бэлтгэл бүлгийн багш нь даалгавар гүйцэтгүүлэхийн өмнө зохиол уншиж өгнө.

ГЭДЭС НЬ ӨЛССӨН АВГАЛДАЙ. <https://www.youtube.com/watch?v=vmXT9YSH4VE>

Сарны гэрэлд навчин дээр нэг жижигхэн өндөг харагдана.

Бүтэн сайн өдрийн нэгэн дулаахан өдөр боллоо. Өнөөх өндөгнөөс ПӨГ гээд жижигхэн авгалдай гарч ирэв. Авгалдайн гэдэс маш их өлсөж байлаа.

Гэдэс нь өлссөн авгалдай юм олж идэхээр мөлхөв. Нэгдэх өдөр тэр нэг алим нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлсөөд л байлаа. Хоёр дахь өдөр хоёр лийр нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлсөөд л байлаа.

Гуравдахь өдөр тэр гурван чавга нүхэлж идэв. Гэвч гэдэс нь өлссөн хэвээрээ л байлаа. Дөрөв дэх өдөр дөрвөн гүзээлзгэнэ нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлссөн хэвээрээ л байлаа. Тав дахь өдөр таван жүрж нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлссөн хэвээрээ л байв. Харин хагас сайн өдөр авгалдай нэг зүсэм шоколадтай бялуу, нэг зайрмаг, нэг өргөст хэмх, нэг зүсэм бяслаг, нэг хэрчим хиам, нэг модон чихэр, нэг зүсэм интоортой боов, нэг зайдас, нэг жижиг кекс, нэг зүсэм тарвас нүхэлж иджээ. Орой болоход авгалдайн гэдэс маш ихээр өвдөж гэнэ. Дараагийн өдөр нь дахиад л бүтэн сайн өдөр боллоо. Авгалдай амттай ногоон навч олж идэв.

Ашгүй гэдэс нь зүгээр болжээ. Авгалдайн гэдэс ч өлсөхөө болилоо. Жижигхээн байсан авгалдай ийм том тарган болж хувирав.

Удалгүй авгалдай өөртөө жижигхэн бүрхүүлэн гэр барилаа.









Авгалдай гэр дотроо 2 долоо хоног гаруй амьдарчээ. Дараа нь бүрхүүлээ цоолоод нүх гаргав.


Тэгээд хамаг чадлаараа зүтгэсээр гадагшаа гартал ийм гоё эрвээхэй болчихсон байлаа.









Даалгаврын дугаар: 1	Бүлэг: Бэлтгэл
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Хэл яриа 2. Математикийн энгийн төсөөлөл
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III	Танин мэдэхүйн түвшин: 1. Сэргээн санах 2. Үнэлэх
Илрүүлэх чадвар: 1. Үлгэр, зохиолын үйл явдлыг ойлгомжтой, дэлгэрэнгүй ярих, зохиомжлон ярих 2. Тооны цифр хэрэглэх, дүн тоог хэлэх	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Үлгэр яриарай.	
Хэрэглэгдэхүүн	“Гэдэс нь өлссөн авгалдай” зохиол үйл явдлыг харуулсан бичлэг /бичлэг үзүүлэх боломжгүй тохиолдолд зурагт үзүүлэн/, Алим, чавга, гүзээлзгэнэ, жүрж, зайрмаг, иштэй чихэр, өргөст хэмх, нэг зүсэм тарвасны зургийн доод талд 3 өөр цифр бичсэн дасгал ажлын хуудас, харандаа	
Даалгаврын заавар	Зохиолыг сонсоод, үйл явдлын дарааллыг нэрлэж, ярина. Өгөгдсөн зургаас авгалдайн идсэн зүйлийн тоонд тохирох цифрийг сонгож дугуйлна.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	1. Одоо зохиол үйл явдлыг бодож байгаад асуултад хариулаарай. а. Сая ямар нэртэй үлгэр үзсэн бэ? б. Өндөгнөөс юу гарсан бэ? в. Авгалдай хоёр дахь өдөр юу идсэн бэ? г. Дараагийн өдөр нь юу идсэн билээ? д. Бүрхүүлэн гэрийг хэн барьсан бэ? е. Авгалдайн бие нь бүдүүн болсон хэсгийг багшдаа яриад өгөөрэй. 2. Зургийг ажиглаарай. а. Авгалдай хэдэн ширхэг юу идсэнийг сайн бодоорой. б. Эдгээр тооноос авгалдайн идсэн зүйлийн тоонд тохирохыг сонгож дугуйлаарай.	1. Зохиолын үйл явдлыг харуулсан бичлэгийг үзүүлнэ. Даалгавар №1.1 дугаартай үзүүлэнг ашиглана. 2. Авгалдайн идсэн зүйлийн зургийн доод талд 3 өөр цифр бичсэн дасгал ажлын хуудас өгнө. Даалгавар №1.2 дугаартай үзүүлэнг ашиглана. 3. “Авгалдай 1 алим идсэн учраас 1-ийн тоог сонголоо” гээд уг цифрийг дугуйлж зурж үзүүлнэ.
Дэмжлэг	Багш алимны зургийг нэрлээд “Авгалдай 1 алим идсэн учраас 1-ийн тоог сонголоо” гээд уг цифрийг дугуйлж зурж үзүүлнэ.	
Анхаарах зүйл	Даалгаврын зааврыг сайтар уншиж ойлгосон байна.	

Бэлтгэл бүлэг: Хэл яриа, Математикийн энгийн төсөөлөл -“Үлгэр яриарай.”
 Даалгавар №1.2 (хүүхдийн тоогоор)

											
5	2	4	2	1	3	3	2	5	1	2	3
											
4	1	3	3	5	1	8	1	7	1	3	6




											
5	2	4	2	1	3	3	2	5	1	2	3
											
4	1	3	3	5	1	8	1	7	1	3	6

Даалгаврын дугаар: 2	Бүлэг: Бэлтгэл
Хөгжлийн чиглэл: Бие бялдар, Нийгэмшихүй, Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Эрүүл мэнд 2. Хэл яриа 3. Нийгэмшихүй
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III	Танин мэдэхүйн түвшин: 1. Задлан шинжлэх 2. Ойлгох 3. Хэрэглэх
Илрүүлэх чадвар: 1. Биед сайн, муу хүнсийг ялгах, 2. Яагаад? гэсэн асуултад учир шалтгааныг тайлбарлаж нийлмэл өгүүлбэр хэлэх 3. Өгсөн заавар, дүрмийг анхааралтай сонсож, биелүүлэх.	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Сайн муу хүнсийг ялгаарай.	
Хэрэглэгдэхүүн	Алим, самар, өндөг, гүзээлзгэнэ, ааруул, өргөст хэмх, лууван, улаан лооль бялуу, зайрмаг, ундаа, модон чихэр, зайдас, чипс, шоколад, шарсан төмс зэргийг дүрсэлсэн зурагт картууд	
Даалгаврын заавар	Биед сайн хүнсийг ялгаж зүүн, муу хүнсний зургийг баруун талдаа ангилж тавина, Яагаад сонгосон болон сонгоогүй учир шалтгааныг тайлбарлаж ярина.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> 1. Зургийг ажиглаарай. 2. Зургийг нэрлээрэй. 3. Эдгээр зургаас хүний биед сайн хүнсийг олж зүүн талдаа тавиарай. (Алим, самар, өндөг, гүзээлзгэнэ, ааруул, өргөст хэмх, лууван, улаан лооль) 4. Хүний биед муу хүнсийг ялгаж баруун талд нь байрлуулаарай. (бялуу, зайрмаг, ундаа, модон чихэр, зайдас, чипс, шоколад, шарсан төмс) 5. Эдгээр хүнсийг яагаад хүний биед сайн гэж бодсон бэ? Тайлбарлаарай. 6. Хэрвээ хүүхэд сонголт хийгээгүй хүнсний бүтээгдэхүүн үлдсэн бол “Яагаад эдгээрийг сонгож тавиагүй вэ?” гэж асууна. 	<p>Хүнсний бүтээгдэхүүний зурагт картыг ширээн дээр тавина. Даалгавар №2.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</p> <p>Зургийг нэрлэхэд багш дэмжлэг үзүүлж болно.</p> <p>Багш даалгавар гүйцэтгэх зааврыг тодорхой тайлбарлаж хэлнэ.</p>
Дэмжлэг	Сайн хүнснээс нэгийг авч ангилах үйлийг үзүүлнэ. Зарим бүтээгдэхүүний зургийг танихгүй тохиолдолд нэрийг нь хэлж өгнө.	
Анхаарах зүйл	Дэмжлэг хэсэгт бичсэнээс бусад тохиолдолд дөхүүлэх асуулт тавих, зааж чиглүүлэх үйл хийхгүй.	

Бэлтгэл бүлэг: Эрүүл мэнд, Хэл яриа, Нийгэмшихүй -“Сайн муу хүнсийг ялгаарай.” Даалгавар № 2.1


(Нэг хувь хэвлээд, зураг тус бүрийг хайчилж ашиглана.)



Даалгаврын дугаар: 3	Бүлэг: Бэлтгэл
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Байгаль, нийгмийн орчин 2. Дүрслэх урлаг
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III	Танин мэдэхүйн түвшин: 1. Задлан шинжлэх 2. Бүтээх
Илрүүлэх чадвар: 1. Юмс, үзэгдэлтэй холбогдох “Яагаад?” гэсэн асуулт дэвшүүлж, хамтдаа хариулт олох 2. Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр эд зүйлс, хүн, амьтан дүрслэх	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай



Даалгавар	Баримлаар наадаарай.	
Хэрэглэгдэхүүн	Эрвээхэй үүсэх үйл явцын дарааллыг харуулсан зурагт карт, эрвээхэй хийх аргачлалын зураг, баримлын шавар, баримлын суурь, баримлын хутга, жижиг сагс, гар арчих алчуур	
Даалгаврын заавар	Эрвээхэйн үүслийг харуулсан зургийг дарааллын дагуу байрлуулж, тайлбарлана. Баримлын шавраар эрвээхэй хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<p>1. Эрвээхэй хэрхэн бий болсон бэ? Сайн бодоорой.</p> <p>a. Эрвээхэйн үүслийг харуулсан зургийг ажиглаад дарааллын дагуу байрлуулж тавиарай.</p> <p>b. Зургийн дарааллыг тайлбарлаад өгөөрэй.</p> <p>2. Одоо энэ аргачлалын дагуу баримлын шавраар эрвээхэй бүтээгээрэй.</p> <p>a. 2-3 өнгө сонгож, баримлын шавраа атгаж зөөлрүүлнэ.</p> <p>b. Баримлаа 3 том, 3 жижиг хэсэгт хуваана.</p> <p>c. Нэг том баримлаа бөөрөнхийлж цувиад их бие, 1 жижиг баримлаа бөөрөнхийлөөд толгойн хэсгийг хийнэ.</p> <p>d. 2 ижил өнгийн том баримлаа бөөрөнхийлж, хавтгайлан дээд 2 далавч, 2 жижиг баримлаар доод далавчийг мөн адил аргаар хийнэ.</p> <p>e. Их бие, толгой, далавч хэсгүүдийг холбоно.</p> <p>f. Дахин 4 жижиг баримал авч цувих аргаар 2 эвэр, амыг бөөрөнхийлөх, хавтгайлах аргаар нүдийг хийнэ.</p> <p>g. Өөр өөр өнгийн баримлыг цувьж, хавтгайлж далавч хэсгийг чимэглэнэ.</p>	<p>Эрвээхэй үүсэх үйл явцын дарааллыг харуулсан зургийг жижиг сагсанд хийж тавьсан байна.</p> <p>Даалгавар № 3.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</p> <p>Хүүхдээр баримлын шаврыг сонгуулна.</p> <p>Эрвээхэй хийх аргачлал бүхий зураг, баримлын хутга, хулдаас зэргийг өгнө. Даалгавар № 3.2 дугаартай үзүүлэнг ашиглана.</p>
Дэмжлэг	Үзүүлэх дэмжлэг байхгүй.	
Анхаарах зүйл	Баримлаар бүтээл хийхэд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг бэлтгэж өгнө.	

Бэлтгэл бүлэг: Байгаль, нийгмийн орчин, Дүрслэх урлаг -“ Баримлаар наадаарай.”
Даалгавар № 3.1 (Нэг хувь хэвлэнэ.)



Бэлтгэл бүлэг: Байгаль, нийгмийн орчин, Дүрслэх урлаг - "Баримлаар наадаарай." Даалгавар № 3.2

(Хүүхдийн тоогоор хэвлээд хайчилж бэлтгэнэ.)



Даалгаврын дугаар: 4	Бүлэг: Бэлтгэл
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Математикийн энгийн төсөөлөл
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: III	Танин мэдэхүйн түвшин: 1. Задлан шинжлэх
Илрүүлэх чадвар: 1. Дүрсийг өнгөтэй нь нэрлэх	Интеграц эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Дүрсийг нэрлээрэй.	
Хэрэглэгдэхүүн	Иштэй чихэр, зүсэм тарвас, дөрвөлжин бялуу, зүсэм бялуу, өргөст хэмх, бяслагны зурагтай А5 хэмжээтэй цаас, өнгийн харандаа	
Даалгаврын заавар	Аль хүнсний бүтээгдэхүүн ямар дүрстэй ижил байгааг олж, ижил өнгийн харандаагаар дүрсийг зурна.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	Зургийг ажиглаарай. 1. Эдгээр хүнсний зүйлс ямар хэлбэр дүрстэй байна вэ? 2. Ямар өнгөтэй байна вэ? Нэрлээрэй. 3. Одоо өнгийн харандаагаа сонгож аваад, аль хүнсний бүтээгдэхүүн ямар дүрстэй ижилхэн байгааг хоосон хүснэгт дотор зураарай.	А5 хэмжээтэй цаас бүхий дасгал ажлын хуудсыг хүүхдэд өгнө. Даалгавар №4.1 дугаартай үзүүлэнг ашиглана. 3. Зүсэм бялуу ягаан өнгөтэй байгаа учир ягаан харандаа сонгож аваад, бялууны зургийн хажууд гурвалжин дүрс зурна.
Дэмжлэг	Зүсэм бялуу ягаан өнгөтэй байгаа учир ягаан харандаа сонгож аваад, бялууны зургийн хажууд гурвалжин дүрс зурна.	
Анхаарах зүйл	Тарвасыг улаан, ногоон өнгөөр сонгосон тохиолдолд зөв гэж тооцно.	

Бэлтгэл бүлэг: Математикийн энгийн төсөөлөл - "Дүрсийг нэрлээрэй."
Даалгавар № 4.1 (Хүүхдийн тоогоор хэвлэнэ.)



